



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2024 оны 01 сарын 15 өдөр

Дугаар 401

Сүмбэр сум

Бүтэц, орон тоо, албан хаагчдын албан
тушаалын цалинг шинэчлэн тогтоох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, Хөдөлмөрийн тухай хуулийн 101 дугаар зүйлийн 101.1, Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1, 57.2.2, 57.2.4, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт “Засгийн газрын агентлаг, нутгийн захиргааны байгууллага болон төрийн захиргааны бусад байгууллагын төрийн захиргааны албан тушаалын цалингийн хэмжээ”, 10 дугаар хавсралт “Төрийн үйлчилгээний бусад байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээ”, Улсын Их Хурлын 2019 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам”-ын 2.10, Засгийн газрын 2022 оны 491 дүгээр тогтоол “Журамд өөрчлөлт оруулах тухай”, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдэл олгох журам”-ын 4 дэх заалт, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын Нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”-ын 2, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 489 дүгээр тогтоол, “Говьсүмбэр аймгийн Засаг даргын “Байгаль орчин, аялал жуулчлалын газрын орон тоог шинэчлэн тогтоох тухай” 2023 оны 12 сарын 16-ны өдрийн А/09 дүгээр захирамж, Говьсүмбэр аймгийн Засаг даргын “Төрийн захиргааны албан хаагдах орон нутгийн нэмэгдэл олгох тухай” 2024 оны 1 сарын 10-ны өдрийн А/31 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын бүтэц, орон тоог нэгдүгээр хавсралтаар, албан хаагчдын албан тушаалын зэрэглэл, үндсэн цалин, нэмэгдлийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хариуцсан чиг үүргийн хүрээнд хууль тогтоомжийн хэрэгжилтийг бүрэн хангаж, ажиллахыг нийт албан хаагчдад даалгасугай.

4. Албан хаагчдын албан тушаалын цалин, холбогдох нэмэгдлийг хавсралтад заасны дагуу батлагдсан төсвийн цалингийн зардлаас зарцуулахыг нягтлан бодогч (Ц.Цэрэнчимэд)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА  Д.МӨНХ-ЭРДЭНЭ



Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын
2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 01 дүгээр
тушаалын 1 хавсралт

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН БҮТЭЦ, ОРОН ТОО

№	Албан тушаал	Албан тушаалын зэрэглэл	Цалингийн хэмжээ
1	2	3	4
1	Газрын дарга	ТЗ-4	1
2	Байгаль орчны хяналтын улсын байцаагч	ТЗ-7	1
3	Байгаль орчны бодлогын хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээ, хүний нөөц, дотоод ажил хариуцсан ахлах мэргэжилтэн	ТЗ-8	1
4	Нягтлан бодогч	ТУ-8	1
5	Байгаль орчны үнэлгээ, усны асуудал хариуцсан мэргэжилтэн	ТЗ-9	1
6	Ой, цөлжилт, биологийн олон янз байдлын асуудал хариуцсан мэргэжилтэн	ТЗ-9	1
7	Аялал жуулчлал тусгай хамгаалалттай газар нутаг, сургалт, сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн	ТЗ-9	1
8	Сүмбэр сумын байгаль хамгаалагч	ТЗ-9	1
9	Хүрээлэн буй орчны бохирдол, байгалийн гамшиг, газрын асуудал хариуцсан мэргэжилтэн	ТЗ-9	1
10	Архив, бичиг хэргийн эрхлэгч, нярав	ТУ-5	1
11	Улсын тусгай хамгаалалттай газар нутаг хариуцсан харуул хамгаалалтын ахлагч	ТУ-3	1
12	Жолооч	ТУ-3	1
13	Үйлчлэгч	ТУ-1	1



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2024 оны 02 сарын 05 өдөр

Дугаар 402

Сүмбэр сум

Ахмад настанд хүндэтгэл үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.2, Ахмад настны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 14 дүгээр зүйлийн 14.6, Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Ахмадын сан байгуулан ажиллуулах журам"-ын 3.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Хилэнт эх" хэмээх модон луу жилийн хаврын тэргүүн сарын шинийн нэгэн буюу Цагаан сарын баярыг тохиолдуулан байгууллагын харьяа ахмад настанд хүндэтгэл үзүүлж, бэлэг дурсгалын зүйл гардуулах арга хэмжээний зардалд 800,000 төгрөг зарцуулсугай.

2. Ахмад настанд хүндэтгэл үзүүлэх зардал 800,000 (найман зуун мянга) төгрөгийг байгууллагын Ахмадын сангаас зарцуулахыг нягтлан бодогч (Ц.Цэрэнчимэд)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Д.МӨНХ-ЭРДЭНЭ

422401 013



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2024 оны 02 сарын 14 өдөр

Дугаар 108

Сүмбэр сум

Ёс зүйн дэд хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.2, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 13 дугаар зүйлийн 13.1, 13.2, 2024 оны 2 сарын 14-ны өдрийн хамт олны хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэх ёс зүйн дэд хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

ДЭД ХОРООНЫ ДАРГА:

Б.Гандулам - Хяналт-шинжилгээ, үнэлгээ, хүний нөөц, дотоод ажил хариуцсан ахлах мэргэжилтэн


ГИШҮҮД:

Н.Намуунцэцэг - Байгаль орчны үнэлгээ, усны асуудал хариуцсан мэргэжилтэн

М.Номинзул - Ой, цөлжилт, биологийн олон янз байдал хариуцсан мэргэжилтэн

2. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэгжүүлж, жил бүр төлөвлөгөө гарган, хэрэгжилтийг холбогдох байгууллагад тайлагнаж ажиллахыг ёс зүйн дэд хороо (Б.Гандулам)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан газрын даргын 2022 оны А/02 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

ДАРГА  Д.МӨНХ-ЭРДЭНЭ



4224010016



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2024 оны 03 сарын 28 өдөр

Дугаар 704

Сүмбэр сум

Хөрөнгө зарцуулах тухай

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5 дахь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.2 дахь заалт аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 сарын 01-ний өдрийн 20 дугаар хуралдааны 05 дугаар тогтоолын 05 дугаар хавсралтаар батлагдсан "Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар 2024 оны төсвийн жилд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний жагсаалт"-ын 2.7 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Монгол экологи төв" ТББ-аас зохион байгуулж байгаа Дорноговь аймагт зохион байгуулагдах "Youth Power GTD" Байгальд ээлтэй залуусын чуулга уулзалт арга хэмжээнд Говьсүмбэр аймгаас шалгарсан 33 сурагчдад замын зардлын дэмжлэг үзүүлэх, удирдамж, төсвийг хавсралтаар баталсугай.

2. Дээрх арга хэмжээнд шаардлагатай 402,600 (Дөрвөн зуун хоёр мянга зургаан зуу) төгрөгийг Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас зарцуулахыг нягтлан бодогч (Ц. Цэрэнчимэд)-д зөвшөөрсүгэй.

3. Уг үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулж, үр дүнг тайлагнахыг аялал жуулчлал, тусгай хамгаалалттай газар нутаг, сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн (Э.Дашжаргал)-д үүрэг болгосугай.


ДАРГА



Д.МӨНХ-ЭРДЭНЭ

4224010036

Байгаль орчин аялал жуулчлалын газрын
2024 оны 03 сарын 28-ны өдрийн
тушаалын хавсралт



**“YOUTH POWER GTD” БАЙГАЛЬД ЭЭЛТЭЙ ЗАЛУУСЫН ЧУУЛГАНЫ
АРГА ХЭМЖЭЭНИЙ УДИРДАМЖ**

2024.03.28

Нэг: Нийтлэг үндэслэл:

Байгаль орчны хамгаалах хууль тогтоомжийг сурталчлах, Уур амьсгалын өөрчлөлт, дэлхийн дулаарлын талаар өсвөр үеийнхэн, залууст идэвхтэй амьдрах чадвар бүхий байгаль орчны, тогтвортой хөгжлийн мэдлэг мэдээлэл олгох, бүх түвшний шийдвэр гаргах явцад хүүхдийн оролцоог нэмэгдүүлэх, тогтвортой хөгжлийн боловсрол олгох, иргэдийн байгаль хамгаалах мэдлэг, хандлагыг дээшлүүлэх арга хэмжээ аливаа шийдвэр тогтоолууд байгальд ээлтэй байх шаардлагыг хангахад залуус хувь нэмрээ оруулах байдлыг дэмжих

Хоёр. Зорилго:

Аймгийн ахлах ангийн сурагчдад хүрээлэн буй орчинд тулгамдаж буй экологийн болон, уур амьсгалын өөрчлөлтийн талаар мэдлэг олгох, бусад аймаг сумдын онцлог, ялгаатай байдлыг таниулах байдлаар оролцогчдын бодит оролцоог хангаж, өсвөр үеийхэнд тогтвортой хөгжлийн боловсролыг олгох, байгальд ээлтэй залуу манлайлагчдыг бэлтгэх, эко бүлгийн сурагчидтай хамтран ажллах, байгальд ээлтэй Go To Dream уриатай 3 аймгийн чуулганд аймгийн хүүхэд, залуусыг оролцоход дэмжлэг үзүүлэх

Гурав. Хугацаа, байршил

“Youth Power GTD 2024” чуулган 2024 оны 03 сарын 30,31-ний өдөр Сайншанд хотын Соёмбо цогцолборт

Дөрөв. Хамрах хүрээ

Зохион байгуулагч:

- “Монгол Экологи төв” ТББ

Хамтрагч:

- Дорноговь аймгийн БСШУГ
- Дорноговь аймгийн ЗДТГ

Дэмжигч:

- Дорноговь аймгийн БОАЖГ
- Говьсүмбэр аймгийн БОАЖГ
- Төв аймгийн БОАЖГ
- Говьсүмбэр аймгийн Гэр бүлийн хөгжил, хамгаалалын газар


Оролцогч

- Говьсүмбэр аймгийн ЕБС-ийн 9-12 дугаар ангийн 33 сурагч

Тав. Хүрэх үр дүн:

- Оролцогч хүүхдүүд өөрсдийн оршин суугаа газарт тулгамдаж байгаль орчин буй түүхэн дурсгалт газар, өв соёлтой холбоотой асуудлуудыг хэлэлцэнэ.
- Тогтвортой хөгжлийн боловсрол олгох, өсвөрийн байгаль хамгаалагч, сургагч багш бэлтгэх,
- Эко бүлгийн Багаар ажиллах чадварт суралцана. Эко бүлгийн сурагчидтай салбарын үйл ажиллагааг хамтран зохион байгуулах
- Монгол улсад тулгамдаж буй байгаль орчны асуудлуудыг тодорхойлно
- Зохион байгуулагчийн баталсан хөтөлбөрийн дагуу арга хэмжээнд оролцсон байна.

Байгаль орчин аялал жуулчлалын газрын
2024 оны 03 сарын 28-ны өдрийн
404 тушаалын хавсралт



2024.03.28

“YOUTH POWER GTD” БАЙГАЛЬД ЭЭЛТЭЙ ЗАЛУУСЫН ЧУУЛГАНД
ОРОЛЦОХ ТӨСӨВ

№	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ /төг/
1	Чуулганд оролцогчдын замын зардал	төг	33	12,200.0	402,600.0
2	Нийт				402,600.0

Жич: Хавсралтаар оролцогчдын мэдээллийг хавсаргав.

Төсөв хийсэн: Мэргэжилтэн
Хянасан: Ня-бо

Э. Дашжаргал
Ц. Цэрэнчимэд



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2024 оны 04 сарын 02 өдөр

Дугаар 4/05

Сүмбэр сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.2, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2023 оны 12 сарын 01-ний өдрийн 05 дугаар тогтоолын 05 дугаар хавсралт “Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар 2024 оны төсвийн жилд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний жагсаалт”-ын 1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд автозам дагуу ойн зурвасын хамгаалалтын хашааг сэргээн засварлахад ашиглах хашааны материал худалдан авах ажлыг хүлээж авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

АЖЛЫН ХЭСГИЙН ДАРГА:

М.НОМИНЗУЛ - Ой, цөлжилт, биологийн олон янз байдлын асуудал хариуцсан мэргэжилтэн.

ГИШҮҮД:

Ц.УРАНБАЯР - Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн /зөвшилцсөнөөр/

Б.ГАНДУЛАМ – Хяналт-шинжилгээ, үнэлгээ, хүний нөөц, дотоод ажил хариуцсан ахлах мэргэжилтэн

Т.ДАШЦЭДЭН - Сум дундын Ойн ангийн дарга

Т.ШУУХААЗ - Сум дундын Ойн ангийн нярав

Б.БАТТҮВШИН - “Жавхлант ариувжих” ХХК-ийн захирал /Гүйцэтгэгч байгууллагыг төлөөлөл /

4224010027

2. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд автозам дагуу ойн зурвасын хамгаалалтын хашааг сэргээн засварлахад ашиглах хашааны материал худалдан авах ажлын гүйцэтгэлийг холбогдох хууль, дүрэм журмын дагуу хүлээн авч, үр дүнг тайлагнахыг ажлын хэсгийн дарга (М.Номинзул)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.МӨНХ-ЭРДЭНЭ